

ЕРӨНХИЙ ХЯНАЛТЫН СОНСГОЛЫН ТАЙЛАН

СЭДЭВ: Монгол Улсын Хөгжлийн банкнаас санхүүжүүлсэн төсөл, хөтөлбөрийн хэрэгжилтэд хяналт тавьж, шалгалт хийсэн талаарх холбогдох эрх бүхий байгууллагуудын тайлан, мэдээлэлтэй танилцах

2022 оны 04 дүгээр
сарын 04-ний өдөр

Улаанбаатар
хот

Монгол Улсын Их Хурлын 2022 оны ээлжит бус чуулганы 01 дүгээр сарын 31-ний өдрийн хуралдаан дээр Улсын Их Хурлын гишүүн Б.Бат-Эрдэнэ, Ч.Хүрэлбаатар, Д.Ганбат, Б.Баттөмөр, Б.Пүрэвдорж, Б.Энх-Амгалан нарын гишүүд Хөгжлийн банкны асуудлаар Улсын Их Хурлаас анхаарах, шаардлагатай бол хяналт шалгалт хийх асуудлыг хөндсөн бөгөөд гишүүдийн саналыг Улсын Их Хурлын дарга Г.Занданшатар дэмжиж, 2022 оны 01 дүгээр сарын 31-ний өдрийн 20 дугаар захирамжаар “Монгол Улсын Хөгжлийн банкнаас санхүүжүүлсэн төсөл, хөтөлбөрийн хэрэгжилтэд хяналт тавьж, шалгалт хийсэн талаарх Монгол Улсын Засгийн газар, Монголбанк болон аудитын тайлан, дүгнэлт, зөвлөмжтэй танилцаж дүнг Улсын Их Хуралд танилцуулах үүрэг бүхий ажлын хэсэг”-ийг Улсын Их Хурлын гишүүн Б.Баттөмөрөөр ахлуулан, ажлын хэсгийн гишүүдэд Улсын Их Хурлын гишүүн Б.Бат-Эрдэнэ, Ц.Даваасүрэн, Б.Пүрэвдорж, С.Чинзориг нарын бүрэлдэхүүнтэй байгуулсан болно.

Түүнчлэн Улсын Их Хурлын гишүүн Б.Баттөмөр, Ш.Адъяаа, Ж.Бат-Эрдэнэ, Ц.Даваасүрэн, Ж.Мөнхбат, Ц.Сэргэлэн, Г.Тэмүүлэн, Н.Учрал, Д.Цогтбаатар нарын гишүүдээс Улсын Их Хурлын дарга Г.Занданшатарт хандан 2022 оны 03 дугаар сарын 04-ний өдрийн УИХ-03/1818 дугаар албан бичгээр Монгол Улсын Хөгжлийн банкнаас санхүүжүүлсэн төсөл, хөтөлбөрийн хэрэгжилтэд хяналт тавьж, шалгалт хийсэн талаарх асуудлаар Ерөнхий хяналтын сонсгол зохион байгуулах тухай хүсэлт хүргүүлсэн.

Уг хүсэлтийг Эдийн засгийн байнгын хороо 2022 оны 03 дугаар сарын 11-ний өдрийн хуралдаанаараа хэлэлцээд 01 дүгээр тогтоолоор “Монгол Улсын Хөгжлийн банкнаас санхүүжүүлсэн төсөл, хөтөлбөрийн хэрэгжилтэд хяналт тавьж, шалгалт хийсэн талаарх холбогдох эрх бүхий байгууллагуудын тайлан, мэдээлэлтэй танилцах Ерөнхий хяналтын сонсгол”-ыг зохион байгуулахаар шийдвэрлэсэн бөгөөд сонсгол даргалагчаар Улсын Их Хурлын гишүүн Ж.Бат-Эрдэнийг томилсон.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 118 дугаар зүйлийн 118.2 дахь хэсэг, Нийтийн сонсголын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 дэх хэсэгт заасны дагуу Ерөнхий хяналтын сонсгол болох талаар тов, мэдээллийг 2022 оны 03 дугаар сарын 11-ний өдрөөс эхлэн 24-ний өдрийн 17.30 цаг хүртэл олон нийтийн хэвлэл, мэдээллийн хэрэгслээр мэдээлж, сонсголд оролцогчдыг бүртгэсэн.

2022 оны 03 дугаар сарын 29-ний өдөр Төрийн ордны “Жанжин Д.Сүхбаатар” танхимд Монгол Улсын Хөгжлийн банкнаас санхүүжүүлсэн төсөл, хөтөлбөрийн хэрэгжилтэд хяналт тавьж, шалгалт хийсэн талаарх холбогдох эрх бүхий байгууллагуудын тайлан, мэдээлэлтэй танилцах Ерөнхий хяналтын сонсголыг зохион байгуулсан болно.

Сонсголыг Улсын Их Хурлын гишүүн, Сонсгол даргалагч Жадамбын Бат-Эрдэнэ нээж, сонсгол зохион байгуулах болсон үндэслэл, сонсголын зорилго, оролцогчдын ирц, сонсголын дэг, дараалал, сонсголд оролцогчдын эрх, үүргийг танилцуулснаар эхэллээ.

Сонсголд Улсын Их Хурлын нийт 27 гишүүн оролцсоноос Нийтийн сонсголын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.5-д заасны дагуу Эдийн засгийн байнгын хорооны 14 гишүүд хүрэлцэн ирж, хуулийн дагуу Ерөнхий хяналтын сонсголын ирц бүрдсэн болно.

Мөн сонсголд Улсын Их Хурлын гишүүдээс гадна:

- Засгийн газрын Хэрэг эрхлэх газар, Сангийн яам, Хууль зүй, дотоод хэргийн яам, Эдийн засаг, хөгжлийн яам, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам, Барилга, хот байгуулалтын яам, Үндэсний Аудитын газар, Санхүүгийн зохицуулах хороо, Татварын ерөнхий газар, Улсын бүртгэлийн ерөнхий газар, Гаалийн ерөнхий газар, Монгол Улсын ерөнхий прокурорын газар, Авлигатай тэмцэх газар, Цагдаагийн ерөнхий газар, Барилгын хөгжлийн төв, Монголбанк, Хөгжлийн банк зэрэг холбогдох төрийн байгууллагын удирдах албан тушаалтан;
- Улсын Их Хурал дахь Монгол Ардын Намын бүлгийн ажлын алба, Улсын Их Хурал дахь Ардчилсан Намын бүлгийн ажлын алба, Монгол Ардын Нам, Хөдөлмөрийн Үндэсний Нам зэрэг улс төрийн намын төлөөлөл 11 оролцогч;
- Монголын Үндэсний Худалдаа Аж Үйлдвэрийн Танхим, Монголын банкны холбоо, Монголын мэргэшсэн үнэлгээчдийн институт, Монгол-Брэнд холбоо, Авлигатай тэмцэх газрын дэргэдэх Олон нийтийн зөвлөл, “Ард түмний штаб”, Компанийн засаглалын Үндэсний зөвлөл, Монголын хуульчдын холбоо зэрэг төрийн бус байгууллагын төлөөлөл 12 оролцогч;
- “НВЦ” ХХК, “Монполимет” группийн “Монцемент Билдинг Материалс” ХХК, “Прайсоутерхаускуперс” ХХК, “Эрэл групп” ХХК, “Хөтөлийн цемент шохой” ХК, “Вестерн Холд” ХХК, “Монгол драй милк” ХХК, “Инжир” ХХК, “Кью Эс Си” ХХК, “Ганхүдэр Орд” ХХК, “Алтан Дорнод Монгол” ХХК, “Бэрэн групп” ХХК зэрэг аж ахуйн нэгжийн төлөөлөл 15 оролцогч,
- Монгол Контент ХХК, ТВ-8 телевиз, Харах өнцөг студи, Монгол ТВ, “Улаан бал” нэвтрүүлэг, ТВ24 телевиз, Зариг.мн, UBN.mn, ERENNews.mn, FACETV.mn, Dardas.mn, Цахиур.мн зэрэг хэвлэл мэдээллийн байгууллагын хэвлэл мэдээллийн төлөөлөл 21 оролцогч болон иргэдийн 14 төлөөлөл нийт 170 гаруй оролцогч оролцсон болно.

Сонсголын ажиглагчаар Монголын хуульчдын холбооны гишүүн, хуульч Ч.Отгонбаатар, Г.Давааням, “Монполимет” группын “Монцемент Билдинг Материалс” ХХК-ийн Худалдан авалтын хэлтсийн менежер, хуульч Д.Дэлгэр, ХҮН-ын Удирдах зөвлөлийн дарга Б.Найдалаа нар ажиллалаа.

Сонсголын эхэнд Улсын Их Хурлын гишүүн Б.Энхбаяр Монгол Улсын хяналт шалгалтын тухай хууль батлагдсантай холбоотойгоор хамгийн анхны Ерөнхий хяналтын сонсголыг зохион байгуулахдаа сонсголыг агуулга, зорилготой нь сайн холбож ойлгох ёстой. Улсын Их Хурлын гишүүд асуулт асууж, хариулт авахдаа ард

түмнийг төлөөлж асууж байгаа нь Парламентын хяналтын нэг хэлбэр бөгөөд Парламент ард түмнийг төлөөлөх дээд байгууллагынхаа хувьд асуулт асуух эрхтэй гэдгийг онцолсон.

Түүнчлэн Улсын Их Хурлын гишүүн Б.Энхбаяр, Ч.Хүрэлбаатар, Т.Доржханд, Н.Алтанхуяг, Ш.Адъяа нараас Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 120 дугаар зүйлийн 120.1.3-т “сонсголд дуудаж ирүүлсэн албан тушаалтан нь тухайн сэдвээр мэдээлэл өгөх эрх бүхий албан тушаалтан мөн эсэх талаар тодруулга авах”; гэж заасны дагуу сонсголд холбогдох эрх бүхий байгууллагын удирдлагыг оролцуулах горимын санал гаргалаа.

Сонсгол даргалагч, Улсын Их Хурлын гишүүн Ж.Бат-Эрдэнэ уг саналыг дэмжиж, Авлигатай тэмцэх газрын дарга, Тэргүүн комиссар З.Дашдаваа, Цагдаагийн ерөнхий газрын дарга, Дотоодын цэргийн командлагч Ж.Болд, Монгол Улсын Ерөнхий аудитор Д.Занданбат, Монгол Улсын Ерөнхий прокурор Б.Жаргалсайхан, Монголбанкны Ерөнхийлөгч Б.Лхагвасүрэн болон бусад байгууллагуудын удирдлагуудыг дуудаж, сонсголд оролцуулах талаар Улсын Их Хурлын Тамгын газарт чиглэл өгсөн болно.

НЭГ. ХӨГЖЛИЙН БАНКНААС САНХҮҮЖҮҮЛСЭН ТӨСӨЛ, ХӨТӨЛБӨРИЙН ХЭРЭГЖИЛТИЙН БАЙДАЛД ХИЙСЭН ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН ТАЛААРХ БОЛОН ТӨСӨЛ, ХӨТӨЛБӨР ХЭРЭГЖҮҮЛЖ БУЙ АЖ АХУЙН НЭГЖИЙН ТӨЛӨӨЛЛӨӨС ХИЙСЭН ТАЙЛАН МЭДЭЭЛЭЛ СОНСОХ

1.Сонсголын тайлан, мэдээлэл сонсох хэсэгт Хөгжлийн банкнаас санхүүжүүлсэн төсөл, хөтөлбөрийн хэрэгжилтэд холбогдох төрийн байгууллагуудаас хийсэн хяналт шалгалтын талаар дараах мэдээллийг танилцууллаа. Үүнд:

- Монгол Улсын Хөгжлийн банкнаас санхүүжүүлсэн төсөл, хөтөлбөрийн хэрэгжилтийн байдалд хяналт шалгалт хийсэн Улсын Их Хурлын ажлын хэсгийн тайлан, мэдээллийг Улсын Их Хурлын гишүүн, Ажлын хэсгийн ахлагч Баагаагийн Баттөмөр; */Танилцуулгын дэлгэрэнгүй мэдээллийг Хавсралт 1-ээс үзнэ үү./*
- Монгол Улсын Засгийн газраас 2019 онд Монгол Улсын Хөгжлийн банканд хийсэн хяналт шалгалтын талаарх тайлан мэдээлэл, хяналт шалгалтын үр дүнгээс гарсан зөвлөмжийг Засгийн газрын гишүүн, Сангийн сайд Болдын Жавхлан; */Танилцуулгын дэлгэрэнгүй мэдээллийг Хавсралт 2-оос үзнэ үү./*
- Төрийн аудитын байгууллагаас Монгол Улсын Хөгжлийн банкны үйл ажиллагаа, зээл олголтын үр дүн, эргэн төлөлтийн байдалд хийсэн гүйцэтгэлийн аудитын тайлан, аудитын үр дүнд Улсын Их Хурал, Засгийн газар, Хөгжлийн банкны Төлөөлөн удирдах зөвлөлд хүргүүлэх анхаарах асуудлын талаар Үндэсний аудитын газрын Аудитын 3-р газрын захирал Д.Энхболд; */Танилцуулгын дэлгэрэнгүй мэдээллийг Хавсралт 3-аас үзнэ үү./*
- Монгол Улсын Хөгжлийн банкны өнөөгийн байдал, санхүүжүүлсэн төсөл, хөтөлбөрийн хэрэгжилтийн явц, үр дүн, тулгамдаж буй асуудлууд, Хөгжлийн банкны өнөөгийн нөхцөл байдал, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний

талаарх танилцуулгыг Монгол Улсын Хөгжлийн банкны гүйцэтгэх захирал Н.Мандуул; /Танилцуулгын дэлгэрэнгүй мэдээллийг Хавсралт 4-өөс үзнэ үү./

- Монголбанкнаас Монгол Улсын Хөгжлийн банканд хийсэн хяналт шалгалт, шалгалтаас гарсан үр дүн, цаашид авах арга хэмжээний талаарх танилцуулгыг Монголбанкны Ерөнхийлөгч Б.Лхагвасүрэн /Танилцуулгын дэлгэрэнгүй мэдээллийг Хавсралт 5-аас үзнэ үү./ нар тус тус танилцууллаа.

2.Нийтийн сонсголын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.2-т заасны дагуу албан бичгээр мэдээлэл хийх санал, хүсэлтээ ирүүлсэн аж ахуйн нэгжийн танилцуулга, мэдээллийг сонсох ажиллагааны хүрээнд хүсэлт ирүүлсэн “Монцемент Билдинг Материалс” ХХК, “Вестерн Холд” ХХК, “Эрэл” групп” ХХК, “Монгол драй милк” ХХК зэрэг 4 компаниас дараах мэдээллийг танилцууллаа. Үүнд:

- Хөгжлийн банкнаас санхүүжүүлсэн “Монполимет” группийн “Монцемент Билдинг Материалс” ХХК-ийн төсөл, хөтөлбөрийн хэрэгжилтийн явц, өнөөгийн нөхцөл байдлын талаарх танилцуулгыг тус компанийн үйл ажиллагаа хариуцсан захирал Ц.Халиун; /Танилцуулгын дэлгэрэнгүй мэдээллийг Хавсралт 6-аас үзнэ үү./
- “Вестерн Холд” ХХК-ийн Хөгжлийн банкнаас санхүүжүүлсэн төслийн талаарх танилцуулгыг Төслийн удирдагч С.Жавхланбаатар; /Танилцуулгын дэлгэрэнгүй мэдээллийг Хавсралт 7-оос үзнэ үү./
- Хөгжлийн банкнаас санхүүжүүлсэн “Эрэл групп” ХХК-ийн төсөл, хөтөлбөрийн талаарх мэдээллийг тус компанийг үүсгэн байгуулагч Б.Эрдэнэбат; /Танилцуулгын дэлгэрэнгүй мэдээллийг Хавсралт 8-аас үзнэ үү./
- “Монгол драй милк” ХХК-ийн Хөгжлийн банкны санхүүжилтээр хэрэгжүүлж буй төслийн өнөөгийн явцын талаарх мэдээллийг тус компанийг төлөөлж Х.Батбаасан /Танилцуулгын дэлгэрэнгүй мэдээллийг Хавсралт 9-өөс үзнэ үү./ нар тус тус танилцууллаа.

ХОЁР. ТАНИЛЦУУЛГА, ТАЙЛАН МЭДЭЭЛЭЛТЭЙ ХОЛБОГДУУЛАН УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮДИЙН АСУУЛТ, ХАРИУЛТ

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 120 дугаар зүйлийн 120.1.5-д “*гишүүн оролцогчоос асуулт асуух, хариулт авах хугацаа 20 хүртэл минут байх бөгөөд энэ хугацаанд багтаан хэдэн ч асуулт асууж, хариулт авч болно.*”, Нийтийн сонсголын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.1-д “*сонсголд оролцогч энэ хууль болон холбогдох хуульд заасан үндэслэл, журмын дагуу асуултад хариулах, тайлбар, санал хэлэх эрх эдэлнэ.*” гэж заасны дагуу сонсголд оролцсон Улсын Их Хурлын гишүүн Т.Аюурсайхан, С.Одонтуяа, Н.Алтанхуяг, Ш.Адъяаа, Б.Бат-Эрдэнэ, Д.Батлут, Х.Булгантуяа, Т.Доржханд, Ц.Даваасүрэн, Ц.Мөнхцэцэг, М.Оюунчимэг, Б.Пүрэвдорж, Ч.Хүрэлбаатар, Ц.Цэрэнпунцаг, С.Чинзориг, Л.Энх-Амгалан нарын 16 гишүүн асуулт асууж, холбогдох албан тушаалтнаас хариулт авлаа.

Асуулттай холбогдуулан Улсын Их Хурлын даргын захирамжаар байгуулагдсан “Монгол Улсын Хөгжлийн банкнаас санхүүжүүлсэн төсөл, хөтөлбөрийн хэрэгжилтэд хяналт тавьж, шалгалт хийсэн талаарх Монгол Улсын

Засгийн газар, Монголбанк болон аудитын тайлан, дүгнэлт, зөвлөмжтэй танилцаж дүнг Улсын Их Хуралд танилцуулах үүрэг бүхий” ажлын хэсэг, Сангийн яам, Авлигатай тэмцэх газар, Монголбанк, Хөгжлийн банк, Монгол Улсын Ерөнхий прокурор, Төрийн аудитын байгууллага зэрэг байгууллагын удирдлага, холбогдох албан тушаалтан хариулт өгсөн болно.

Асуулт асуусан Улсын Их Хурлын гишүүдийн асуултыг тоймлон дурдвал:

1.Улсын Их Хурлын гишүүн С.Одонтуяа: - Монгол Улсын Хөгжлийн банкнийг шалгах ажлын хэсгүүдийн шалгалтын баримт бичиг, материалууд нууцаас гарсан эсэх, 2021 онд Монгол Улсын Хөгжлийн банканд хийсэн ажлын хэсгийн дүгнэлтийн талаар, 2017 онд Хөгжлийн банкны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулснаар банкны үйл ажиллагаа хяналтгүй болох нөхцөл бүрдсэн гэх ойлголт нь зөв эсэх, зээл олгосон эрх бүхий албан тушаалтнуудад холбогдох хуулийн хариуцлага тооцсон эсэх, гүйцэтгэх захирал болон Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдэд цаашид хэрхэн хариуцлага хүлээлгэх талаар болон одоогийн Төлөөлөн удирдах зөвлөлд арилжааны банкны төлөөлөл байдаг эсэх, хэрэв байдаг бол ямар албан тушаалтан томилдог талаар, өмнө ажиллаж байсан ажлын хэсгүүдийн өгсөн зөвлөмжийн үр дүн болон Газрын тосны үйлдвэрийн газар дээрх бүтээн байгуулалтын талаар асуулт асууж, холбогдох албан тушаалтнуудаас хариулт авлаа.

2.Улсын Их Хурлын гишүүн Т.Доржханд: - Нэгдүгээрт хуулийн хариуцлага, хоёрдугаарт улс төрийн хариуцлага, гуравдугаарт ёс зүйн хариуцлага, дөрөвдүгээрт санхүүгийн хариуцлагын хүрээнд дараах асуултыг асуулаа. Үүнд:

- Хөгжлийн банктай холбоотой асуудлаар өмнөх болон одоо байгаа гишүүдээс мэдүүлэг авсан эсэх, нэр холбогдож буй Х.Баттулга, Д.Эрдэнэбилэг нараас мэдүүлэг авсан эсэх, Хөгжлийн банкны захирлуудыг сүүлийн саруудад тусгаарлан хорьсон байхад зарим албан тушаалтан болох тухайлбал, Хөгжлийн банкны Эрсдлийн үнэлгээ, удирдлагын газрын захирал хийж байсан Г.Дөлгөөн Монголбанкны Тэргүүн дэд Ерөнхийлөгч болсон нь хуулийн хариуцлага шударга бус харилцан адилгүй байгаа талаар;
- Монгол Ардын намын Ерөнхий нарийн бичгийн дарга Д.Амарбаясгалан өөрийн намын гишүүдтэйгээ хариуцлага тооцсон үр дүнгийн талаар, Ардчилсан намын зүгээс намын нэр бүхий гишүүдэд мөн улс төрийн хариуцлага тооцсон эсэх талаар;
- Улсын Их Хурлын гишүүн, Монгол Улсын Их Хурлын Ёс зүй, сахилга хариуцлагын байнгын хорооны дарга Б.Бат-Эрдэнэ Хөгжлийн банкны асуудалд нэр холбогдсон Улсын Их Хурлын гишүүдэд ёс зүйн ямар хариуцлага хүлээлгэх гэж буй талаар;
- Хөгжлийн банк улсын төсвөөс буюу татвар төлөгчдийн мөнгөөр 762.0 тэрбум төгрөг төлүүлэх нь шударга эсэх, санхүүгийн хариуцлагыг хэрхэн хүлээлгэх талаар асуулт асуусан бөгөөд энэ асуудлаар одоогоор 16 гишүүн Улсын Их Хурлын хянан шалгах Түр хороог байгуулахаар гарын үсэг зурсан талаар дурдлаа.

Түүнчлэн тэрээр өмнө ажиллаж байсан Ерөнхийлөгчтэй холбоо бүхий “Шинэ яармаг” төсөлтэй холбоо бүхий албан тушаалтнууд болон Хөгжлийн банктай холбоотой компаниудын хамаарал бүхий 20 хүнийг яагаад байцаахгүй байгаа талаар асуулт асууж хариулт авсан.

3.Улсын Их Хурлын гишүүн Н.Алтанхуяг: - Монгол Улс анх 600 сая ам.долларын Евро бонд босгож, арилжааны банканд дээр байршуулаагүйгээс хүүгийн алдагдал хүлээсэн эсэх, энэ мөнгөөр юу хийсэн талаар, аудитын дүгнэлтэд дурдсан 17 сая ам.долларын алдагдал хүлээсэн мөн Монголбанканд байршуулаад сар бүр 5.9 сая ам.долларын хүү авч байсан нь үнэн эсэх, “Буянт-Ухаа” 1, 2 дугаар хороолол баригдаж, ашиглалтад ороод 6 жил өнгөрсөн байхад зээлийн эргэн төлөлт хийгдсэн эсэх талаар, зарим аж ахуйн нэгжүүд Хөгжлийн банкнаас авсан зээлээ бүрэн төлөөгүй байхад дахин зээл олгосон талаар, “АСЕМ Вилла”-ийн мөнгө яагаад Хөгжлийн банкнаас гарсан зэрэг асуудлын талаар асуулт асууж, холбогдох албан тушаалтнуудаас хариулт авлаа.

4.Улсын Их Хурлын дэд дарга Т.Аюурсайхан: - Хөгжлийн банкны барьцаа хөрөнгийн үнэлгээг ямар байгууллагын шинжээч, үнэлгээчин хэний шийдвэрээр хийсэн талаар, Хөгжлийн банкны өмнө ажиллаж байсан 4 гүйцэтгэх захирлын үед зээл олгогдсон 1.8 их наяд төгрөгийн чанаргүй зээл экспортыг дэмжиж, импортыг орлох Хөгжлийн банкны бодлогод нийцсэн эсэх талаар, зээл олголтын материалыг хянаж ТУЗ рүү оруулдаг эсэх болон хариуцлага хүлээх этгээд мөн эсэх талаар, УИХ-ын гишүүн Г.Амартүвшин ТУЗ-ийн гишүүн байсан эсэх, одоо албан тушаал хашиж байгаа болон өмнө хашиж байсан хүмүүстэй холбоотой Улсын Их Хурлын гишүүдээс нэр нь дурдагдсан болон Хөгжлийн банкны гүйцэтгэх захирлаар ажиллаж байсан албан тушаалтнуудын талаар, Хөгжлийн банкны өмнөх гурван гүйцэтгэх захирал нь хариуцлага хүлээж байхад нэг нь яагаад үлдээд байгаа талаар, зориулалтын бусаар олгосон Хөгжлийн банкны зээлийг ямар компаниуд авсныг хурдан шуурхай шалган тогтоож, олон нийтийн мэдэх эрхийг хангах, Хөгжлийн банктай холбоотой асуудлаар сэжигтэн, гэрч, яллагдагчаар ямар хүмүүсийг татсан зэрэг асуудлуудын талаар асууж, холбогдох албан тушаалтнуудаас хариулт авлаа.

Улсын Их Хурлын дэд дарга Т.Аюурсайхан хариулттай холбогдуулан дараах 2 саналыг Хөгжлийн банкны удирдлагад хандан гаргасан болно.

- Хөгжлийн банкны 2 охин компанийн талаар задгай тоо, мэдээллийг цахим хуудаст байрлуулах,
- Хөгжлийн банк өөрөө эрсдлээ удирдах чадваргүй болсонтой холбогдуулж хариуцлагыг үнэн шударгаар тооцох зэрэг болно.

5.Улсын Их Хурлын гишүүн С.Чинзориг: - Компаниуд өндөр хүүтэй зээл төлөх нь зөв эсэх, зээл авсан компаниудад ялгамжтай хандсан талаар, яагаад эрсдлийг тооцож санхүүгийнхээ менежментийг хийгээгүй талаар, гүйцэтгэх удирдлагууд банканд тогтвор суурьшилтай ажиллах мэргэжлийн боловсон хүчний талаар арга хэмжээ аваагүй талаар, “Монгол драй милк” ХХК-тай холбоотой шүүх хурлыг Сүхбаатар дүүргийн Уранчимэг гэдэг шүүгч яагаад 10 удаа хойшлуулсан талаар, Прокурор төрийн өмнөөс шүүхэд нэхэмжлэх гаргах эрхтэй эсэх, чанаргүй, хугацаа хэтрэлттэй зээлүүдийг богино хугацаанд төлүүлэх боломж бололцоо прокурорт бий эсэх талаар асуулт асууж, холбогдох албан тушаалтнуудаас хариулт авлаа.

6.Улсын Их Хурлын гишүүн Ц.Мөнхцэцэг: - Хөгжлийн банкны удирдлагуудаас улсад учирсан хохирлыг хэзээ барагдуулж чадах, зээлийн барьцаанд байгаа орон сууц зарагдахад иргэд хохирох эсэх талаар (“Бэрэн групп” ХХК-ийн барьцаанд байгаа байрнаас 100 гаруй зарагдсан), Хөгжлийн банкны асуудалтай холбоотой зарим албан тушаалтны хэргийн хөөн хэлэлцэх хугацаа

дууссан асуудал хэд байгаа, авлигын гэмт хэрэг хөөн хэлэлцэх хугацаанд хамаарах эсэх талаар асуулт асууж, холбогдох албан тушаалтнуудаас хариулт авлаа.

7.Улсын Их Хурлын гишүүн Б.Бат-Эрдэнэ: - Монголбанк болон Сангийн сайдаас Засгийн газрын танилцуулсан 2019 оны шалгалтаар илрүүлсэн зөрчилтэй аж ахуйн нэгжүүдийн жагсаалтыг гаргаж өгөх боломжтой эсэх талаар асуулт асууж, холбогдох албан тушаалтнуудаас хариулт авлаа.

8.Улсын Их Хурлын гишүүн М.Оюунчимэг: - Төв банкны үндсэн зорилго болох төгрөгийн тогтвортой байдлыг хангах болон ханшийн зөрүүнээс үүсэх эрсдлээс хамгаалах ямар ажил хийж байсан талаар, мөн нэмэлтээр ам.долларын ханшийн зөрүүний алдагдал томоохон аж ахуйн нэгжүүдэд дарамт болж байхад Төвбанкны хуульд заасан ханшийн уналтаас урьдчилан сэргийлэх ажлаа хэр хийсэн, тухайн үеийн удирдлагууд үүргээ биелүүлж чадсан эсэх, Хөгжлийн банкнаас гарч байгаа бүх мэдээлэл Төвбанкны мэдээллийн санд байхгүй, тусгагддаггүй байсан нь ямар албан тушаалтантай холбоотой талаар, 2012-2016 онд ажиллаж байсан Монголбанк болон Хөгжлийн банкны удирдлагуудын талаар, хууль бусаар зээл аваад түүнийгээ мөрийтэй тоглоомонд алдчихсан хүмүүсийг хууль, хүчний байгууллага шалгаж буй эсэх талаар, Хөгжлийн банкны үйл ажиллагаанд хийсэн шалгалтаар 740 тэрбумаас 1.2 их наяд төгрөгийг зар сурталчилгаанд зарцуулсан гэх, зарцуулахдаа ямар байдлаар зарцуулсанд гүйцэтгэлийн аудит хийсэн үү, эсвэл ерөнхий дүгнэлт хийсэн эсэх талаар асуулт асууж, холбогдох албан тушаалтнуудаас хариулт авлаа.

9.Улсын Их Хурлын гишүүн Ч.Хүрэлбаатар: - Хөгжлийн банкныг тойрсон асуудлаар 2015 онд буюу 7 жилийн өмнө цөөнх байхдаа ярьж байсан асуудал бөгөөд үүнээс хойш 7 жилийн дараа эргэн яригдаж байгаад баяртай байна гээд хэвлэл мэдээллийнхний дуу хоолой үр дүнд хүрч байгаад талархал илэрхийлсэн.

Мөн тэрээр бүх буруу зүйлийг 2017 оны хууль руу чихэж байгаа ч хуульдаа биш, хууль баталсан ч хуулийг завхруулдаг хүмүүс асуудлыг даамжруулсан гэж хэлээд Хөгжлийн банкны зээлийн барьцааг чөлөөлсөн асуудлыг шалгаж байгаа эсэх, Хөгжлийн банкны байрыг 20 орчим тэрбум төгрөгөөр худалдаж авсан нь зах зээлийн үнээс өндөр байгаад хэрэг үүсгэн шалгасан эсэх, Монголбанкнаас шалгалтын үр дүнд илэрсэн буруу зүйлийг яагаад тухайн үед нь хэлж, залруулаагүй, яагаад дүгнэлт нь өөр өөр байгаа талаарх асуудлуудыг тус тус хөндөж, 2016 онд 3 их наяд төгрөгийг улсын төсөв рүү шилжүүлсний адилаар Х.Баттулгатай холбоотой “Шинэ яармаг” төслийн зээлийг улсын төсөв рүү шилжүүлэхгүй гэх байр суурийг илтгэн хариултыг зөвхөн Улсын Ерөнхий Прокурор Б.Жаргалсайханаас авахаа илэрхийлсэн болно.

10.Улсын Их Хурлын гишүүн Ц.Даваасүрэн: - Ажлын хэсэгт орж ажилласны хувиар саналаа илэрхийлэхдээ ажлын хэсгийн гаргасан тайлан, дүгнэлтээр өөрчлөлт орсон, хариуцлагагүй хандсан зүйл байгаа бол хуулийн байгууллагад өгнө гэдгээ илэрхийлээд цаашид Түр хороо байгуулахад Хөгжлийн банк хамтарч ажиллах хэрэгтэй гэв.

11.Улсын Их Хурлын гишүүн Ц.Цэрэнпунцаг: - Хөгжлийн банк хуулиараа олон улсын нээлттэй сонгон шалгаруулалт явуулаад менежментийн багаа сонгох ёстой ч яагаад өнөөг хүртэл хуулиа хэрэгжүүлдэггүй талаар, 2012 онд ажиллаж эхэлсэн гадаадын менежментийн багийг ямар улс төрчийн зааварчилгаагаар сольсон, ямар улс төрч гол шийдвэр гаргасан талаар, шударгаар бизнесээ хийж

байгаад хохирсон Хөгжлийн банкнаас зээл авч чадаагүй хэдэн газар байгаа талаар, зээлийн бус ханшийн эрсдэлд орсон “Монцемент” төсөл зэрэг сайн зээлдэгчдийн зээл авсан нь буруу юу гэх асуултуудыг асуусан.

Эцэст нь Улсын Их Хурлын гишүүн Ц.Цэрэнпунцаг ханш хамгаалах байгууллага нь үүргээ биелүүлээгүйгээс хувийн аж ахуйн нэгж хохирч байгаа нь шударга биш гээд цаашид Түр хороо байгуулан нарийн шалгах хэрэгтэй гэсэн санал гаргасан болно.

12.Улсын Их Хурлын гишүүн Д.Батлут: - Монгол Улсын Засгийн газрын Бодлогын зөвлөл байгуулах тухай 179 дүгээр тогтоолын 2.2-т заасан “Үүсч болох эрсдлийг урьдчилан тооцож үнэлгээ гаргах үүрэг бүхий дэд ажлын хэсэг”-т ямар улс төрийн хамаарал бүхий ямар этгээдүүд байсан, ямар журмаар ажилласан талаар, Монголын толгой баячуудад хамаарах чанаргүй зээлүүдийг хэн үүрэг өгч олгуулсан талаар, “Хөтөлийн цемент шохойн үйлдвэр”-ийн өрийг Төр төлөх эсэх, Чингис хаан банк зэрэг төлбөрийн чадваргүй, хүнд байдалд байгаа банкуудад ямар учраас мөнгө байршуулаад байгаа талаар, Төрийн өмчит компаниудын 700 гаруй тэрбум төгрөгийн өрийг хэний захиалгаар улсад өгөх гэж байгаа талаар, ямар хоёр хэрэг хөөн хэлэлцэх хугацаа нь дууссан учраас хэрэг үүсгэхгүй байгаа, эндээс ямар хэмжээний хохирол учирсан, хохирлыг хэн хариуцан барагдуулах зэрэг асуудлуудын талаар асуулт асуусан.

Түүнчлэн онцгой эрхтэй байсан ТУЗ-д хариуцлага тооцох ёстой гэсэн санал илэрхийлж, 2012-2014 онд Худалдаа хөгжлийн банкны 13 давхар байшингийн 11, 12 дугаар давхарын 3,394 м.кв газрыг 28.5 тэрбум төгрөгөөр худалдан авах шийдвэрийг гаргасан тухайн үеийн ТУЗ-ийн хараат бус гишүүнээр ажиллаж байсан ХҮН-ын даргад хариуцлага тооцох эсэх зэрэг болон Хөгжлийн банктэй холбоотой асуудлыг шалгах хянан шалгах Түр хороог яаралтай байгуулж, хууль хяналтын байгууллагуудтай хамтарч маш хурдтай ажиллах хэрэгтэй талаар дурдсан болно.

13.Улсын Их Хурлын гишүүн Б.Пүрэвдорж: - Хөгжлийн банкны тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.3-т зааснаар захирал Н.Мандуул нь Олон улсын нээлттэй сонгон шалгаруулалтад орсон эсэх талаар, мөн ажлын хэсэг ажиллахад хүндрэлүүд үүссэн талаар дараах асуудлуудыг хэлэв. Үүнд: Хөгжлийн банканд дээр очоод бичиг баримттай танилцъя гэхээр хууль хяналтын байгууллага аваад явсан, мөрдөн байцаагч шиг аж ахуйн нэгжийн захирлаас ямар улс төрч, эрх мэдэлтэн нөлөөлсөн талаар асуух, компанийн данс тооцоог шалгах боломжгүй байсан тухай, мөн хууль хяналтын байгууллагууд барьцааг нь сулласан болон хөөн хэлэлцэх хугацаагаар хэрэгсэхгүй болгосон зэрэг олон асуудлын улмаас Улсын Их Хурлын Ажлын хэсэг олон нийтийн хүлээлтэд хүрээгүй гэж үзэж буйгаа илэрхийллээ.

Түүнчлэн Хөгжлийн банкнаас олгосон санхүүжилтийн зээлүүдийг 2016 оноос өмнөх болон хойших гэж 2 ангилж үзэж, шалгах хэрэгтэй. 2012-2016 онд нийтдээ 1.7 их наяд төгрөгийг 2 мянга гаруй аж ахуйн нэгжид өгдөг ашигтай ажилладаг, ард түмний банк байсан бол 2016 оны 12 дугаар сард Хөгжлийн банкны тухай хуульд өөрчлөлт оруулаад Хөгжлийн банканд олгох зээлийн асуудлыг төлөөлөн удирдах зөвлөлд эрхийг нь өгснөөс хойш 40 зээлдэгчид л зээл олгосон дарга нарын банк болж алдагдалтай ажиллаж эхэлсэн. Харин Засгийн газар хийж чадахгүй байгаа ажлыг иргэд зориг гаргаад хийж байгаа ажлыг нэмж, санхүүжүүлэх хэрэгтэй гэх саналтай байгаагаа дурдав.

Тэрээр Монголбанк төгрөгийн тогтвортой байх асуудлыг шийдэх үүрэг хүлээдгийн хувьд ханшийн эрсдэлд орж байгаа компаниудын асуудлыг тодорхой хэмжээгээр шийдвэрлэх, Хөгжлийн банктэй хамтран ажиллах, Сангийн яам тодорхой хэмжээгээр үүнд нь оролцох ёстой гэсэн санааг тэмдэглэсэн.

Мөн Хөгжлийн банкиг татан буулгах, нэг талдаа активын удирдлагын компани байгуулж, муу зээлийг нь төлүүлэх арга хэмжээг хэрэгжүүлж, сайн зээлүүдийг нь Хөрөнгө оруулалтын банкаар дамжуулан баталгаажуулах цаг болсон талаар онцолсон.

Эцэст нь Ардчилан намын бүлгийн дарга Д.Ганбатын санаачилсны дагуу 17 гишүүн гарын үсэг зурсан Түр хороо байгуулах санаачилга цааш үргэлжлэн уг Түр хороон дээр парламентын засаглалтай Монгол Улсад парламентын эрх үүрэг ямар хүчтэй байдгийг харуулах цаг болсон тухай тодотгосон болно.

14.Улсын Их Хурлын гишүүн Х.Булгантуяа: - Хөгжлийн банкны удирдлагуудаас 1.8 их наяд төгрөгийн чанаргүй зээлийн 1.2 их наяд төгрөгийн зээлийг 2012-2016 онд олгосон.

Худалдаа хөгжлийн банкны хуульч байсан М.Батсуурийг захиргааны хэргийн танхимын шүүгчээр томилсон байдаг. Гэтэл М.Батсуурийн аав Д.Мишиг “Хөтөлийн цемент шохойн үйлдвэр”-ийг үнэгүйдүүлэн авсан, одоо “Бэйзмент” компанийн 20 хувийг эзэмшигч нь байсан эсэх талаар Хөгжлийн банкныхнаас нэмж тодруулга, тайлбар авахыг хүссэн.

Хөгжлийн банкны Эрсдлийн удирдлагын газрын захирал Бат-Оргил гэх хүн Хөгжлийн банканд 213 тэрбум төгрөгийн өртэй “Кью Эс Си” ХХК-ийн хувьцаа эзэмшигч, компанийн эзэн нь үнэн эсэх, өөрөө өөртөө зээл олгоод өөрийнхөө өрийг өөрөө хариуцдаг байдалд хууль хяналтын байгууллагууд ямар ажлууд хийгээд, түүнээс ямар эргэн төлөлт хийгдсэн, 2016 оны сонгуулийн өмнө зар сурталчилгаа явуулахад зориулаад Блүүмберг телевизтэй сурталчилгааны гэрээнүүд байгуулсан эсэх, Төрийн өмчит компаниудын урсгал зардлуудад ямар хууль эрх зүйн орчинд үндэслэн, яаж мөнгө гаргасан талаар, ямар зарчмаар ялгаатай хүүтэй зээлүүдийг олгосон, төмөр зам тавьж, боомтын шинэчлэл хийхээс зайрмагийн үйлдвэр барих нэн чухал байсан эсэх, гүйцэтгэх удирдлагуудын томилгоо шаардлага хангасан эсэх, цаашид ямар арга хэмжээ авах талаар асууж тодруулсан.

15.Улсын Их Хурлын гишүүн Л.Энх-Амгалан: - Хөгжлийн банкны сэдэв 2015 оноос яригдаж эхэлсэн бөгөөд өнөөдрийн үүссэн нөхцөл байдлыг тухайн үед анхааруулж, аудитын дүгнэлт 2 удаа гаргаж байсан. Уг дүгнэлтийг гаргасан 10 гаруй хүн тухайн үед ажлаасаа халагдсан талаар болон тухайн үед өөрийн биеэр Улсын Их Хурлын түүхэнд анх удаа гишүүний бүрэн эрхээсээ татгалзаж шалгуулах хүсэлтээ гаргаж, Авлигатай тэмцэх газарт шалгуулж байсан. Авлигатай тэмцэх газраас холбогдох нэр бүхий компаниудыг шалгаад хамааралгүй байна гэсэн дүгнэлт гаргаж байсан бол өнөөдрийн Улсын Их Хурлын ажлын хэсгийн мэдээлэлд “Монгема” компанитай хамааралтай гэх ээлжит гүтгэлэг явуулж байна гэлээ.

Улсын Их Хурлын гишүүн Б.Баттөмөр хариулахдаа “Монгема” компанийн муур, нохойны хоол тэжээл боловсруулах үйлдвэр байгуулна гэсэн төслийн 12.8 тэрбум төгрөгийн чанаргүй зээлийг судлаад үзэхээр Л.Энх-Амгалан гишүүнд ямар нэгэн улс төрийн хамаарал байхгүй юм байна гээд, нэр гарсан хүмүүс хууль

хяналтын байгууллагад хандан нэр төрөө цэвэрлэж авах нь зүйтэй гэдэг утгаар оруулсан гэж тайлбарласан.

16.Улсын Их Хурлын гишүүн Ш.Адъяа: - 2012-2016 онд илэрсэн луйврыг 6 жил нуун дарагдуулж байгаад гаргаж ирж байна гэж хардаж байна гээд АСЕМ-ын үед зочид буудлуудад өгсөн 275 тэрбум төгрөгийн зээлийг ямар зочид буудалд өгсөн, тэдгээр нь зээлээ төлсөн эсэх, тухай хүлээн авалтын үеэр хэнд хэчнээн төгрөгийн бэлэг сэлт өгсөн талаар, “Дарханы төмөрлөгийн үйлдвэр”-ийн Хятад улс руу гаргаж байгаа төмрийн хүдрийн хэд хэдэн вагоны цувааг замд нь өртөөн дээр битүүмжилсэн нь зөв ч зөөж явсан хувийн хэвшлийн вагон, тээврийн хэрэгслүүдийг хамт битүүмжилсэн нь улс орны экспортыг дэмжих, вагоны хомсдолд орсон нөхцөлд анхаарч үзэх асуудал гэж үзэн тодруулга авахыг хүссэн.

Мөн зочид буудлын 152 тэрбум төгрөг төлөгдөөгүй байгаа нь ямар зочид буудлууд байгаа талаар, зочид хүлээж авах зориулалтаар зээл авч байгаа нь Хөгжлийн банкны зорилготой нийцэж байгаа талаар ямар дүгнэлттэй байгаа талаар асуухад 2015 оны 330 дугаар тогтоолоор Засгийн газрын тогтоолоор зээл гарсан гэж хариулсан болно.

ГУРАВ. ТАНИЛЦУУЛГА, ТАЙЛАН МЭДЭЭЛЭЛТЭЙ ХОЛБОГДУУЛАН ХЭВЛЭЛ МЭДЭЭЛЛИЙН БАЙГУУЛЛАГЫН ТӨЛӨӨЛЛИЙН АСУУЛТ, ХАРИУЛТ

Ерөнхий хяналтын сонсголыг олон нийтэд сурвалжлан хүргэж байгаа Монгол Контент ХХК, ТВ-8 телевиз, Харах өнцөг студи, Монгол ТВ, “Улаан бал” нэвтрүүлэг, ТВ24 телевиз, Zarig.mn, UBN.mn, ERENNews.mn, FACETV.mn, Dardas.mn, Цахиур.мн зэрэг мэдээллийн байгууллагын төлөөлөл бүхий 12 хэвлэл, мэдээллийн байгууллагуудын мэдээлэх эрхийг хангах үүднээс хэвлэл мэдээллийн 4 байгууллагын сэтгүүлч асуулт асууж, холбогдох Төрийн байгууллагын албан тушаалтан хариулт өглөө.

Асуулттай холбогдуулан Монгол Улсын Хөгжлийн банкнаас санхүүжүүлсэн төсөл, хөтөлбөрийн хэрэгжилтэд хяналт тавьж, шалгалт хийсэн талаарх Монгол Улсын Засгийн газар, Монголбанк болон аудитын тайлан, дүгнэлт, зөвлөмжтэй танилцаж дүнг Улсын Их Хуралд танилцуулах үүрэг бүхий Улсын Их Хурлын даргын захирамжаар байгуулагдсан ажлын хэсэг, Сангийн яам, Авлигатай тэмцэх газар, Монголбанк, Хөгжлийн банк, Улсын Ерөнхий прокурор, Төрийн аудитын байгууллагын удирдлагууд хариулт өгсөн болно.

1.Зариг.мн сайтын Ерөнхий эрхлэгч, сэтгүүлч Н.Өнөрцэцэг: - “Чандмань майнинг” ХХК-тай холбоотой Ж.Мөнхбат гишүүн, Хөгжлийн банкнаас зээл авах материал нь бүрдэж дуусаагүй байхад зээлийн шийдвэр нь гардаг С.Бямбацогт гишүүн байхгүй байгаа, хуулийн байгууллага яагаад ажиллахгүй байгааг асууж, 5 тэрбум төгрөгийн зээл авсан “Сэлэнгийн репорт” ХХК-ийн эзэн гэх Гэндэнпилийн Батдорж нь Ерөнхийлөгчийн ойрын хүн гэж мэдээлсэн ба Улсын Их Хурлын гишүүн Х.Ганхуяг 33 тэрбум төгрөг, “Монгэма” ХХК 15 тэрбум төгрөг, “Бэрэн групп” ХХК 120 тэрбум төгрөг, “Эрэл групп” ХХК 190 тэрбум төгрөг төлнө гээд үзвэл өнөөдөр эндээс 1 их наяд төгрөг босох боломжтой байна гэв.

Асуултад Улсын Ерөнхий Прокурор Б.Жаргалсайхан Мөрдөн шалгах ажиллагаа бол мөрдөгч, прокурор хоёрын шийддэг асуудал бөгөөд нэр дурдагдсан

хүмүүс хэрэв хэрэгт холбоотой гэж үзвэл магадгүй тодорхой цаг хугацааны дараа шалгагдах боломжтой гээд, харин өнөөдрийн ажлын хэсгийн дүгнэлттэй холбоотой хорин хэдэн хүний асуудлыг мөрдөн шалгах байгууллагад ирсний дараа тодорхой ажиллагаа хийгдэх байх гэж хариулсан болно.

2.Улаанбал нэвтрүүлгийн хөтлөгч Ч.Лодойсамбуу: - Улсын Их Хурлын гишүүн Ч.Хүрэлбаатараас 2017 оны хуулиар Сангийн яам, Сангийн сайд Хөгжлийн банкны асуудлаар тодорхой хянах, шалгах үүрэг, эрхтэй болж өөрчлөлт орсноос хойш Сангийн яам ямар шалгалт хийсэн талаар асуугаад, яригдаад байгаа энэ асуудлуудыг шийдэхийн төлөө Ч.Хүрэлбаатар гэдэг хүн дөрвөн жил сайд байхдаа ямар алхам хийсэн талаар асуусан бол Сангийн сайд Б.Жавхлангаас томоохон төслүүдийн Төрийн бодлогын залгамжгүй байдал, хуулийн хэрэгжилттэй холбоотой асуудлууд үүсч байгаатай холбоотойгоор нэг гараараа үйлдвэр байгуулж хөгжихийг дэмжээд нөгөө гараараа Төр нь компаниудынхаа зах зээлийг булааж байгаа хэрэг биш үү гэсэн асуулт тавив.

Улсын Их Хурлын гишүүн, Сангийн сайд Б.Жавхлан зах зээлийн зарчмаараа явах ёстойг дурдаад зээл эргэн төлөлт дээр асуудал үүсэж байгаа учир нь анх өөрсдөө төгрөгийн орлоготой байж ам.долларын зээл авсан явдал бөгөөд Хөгжлийн банкны хувьд ам.долларын эх үүсвэртэй байсныгаа төгрөгөөр өгвөл өөрөө алдагдалд орох тул ам.долларын зээл тулгаж, валютын зохицуулалт хийлгүй явсан тухай хэлэв.

Мөн төслийн зээлүүдийг төлүүлэх олон арга замууд байгаагаас төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдэх барилгын ажлуудын 20-30 хувьд нь цементийн худалдан авалт хийгдэх тул зардлуудыг компани руу нь шилжүүлэхгүй Хөгжлийн банкных нь зээлд төлүүлэх зэрэг хувилбарууд санал болгоод судалгаа хийгээд явж байгаа гэв.

3.Дардас.мн-ий сэтгүүлч Б.Өнөртогтох: - 1.8 их наядыг авсан 79 төсөл дотор хөгжлийн төсөл бий эсэх, сайн түүхтэй нэг ч гэсэн аж ахуйн нэгж байгаа бол нэрлэх, шаардлага хангаагүй аж ахуйн нэгжүүдэд зээл өгсөн байгааг нэрлэж өгнө үү гээд улс төрчдийн хувьд санал нэгдэн валютын ханшийн зөрүүнээс алдагдал хүлээсэн аж ахуйн нэгжүүдийн талаарх асуудлыг хөндөж байгаа нь чухал санагдсан талаар саналаа хэлээд ханшийн зөрүүнээс эрсдэл хүлээсэн аж ахуйн нэгжүүдтэйгээ гурван талт хэлэлцээрт орох буюу Хөгжлийн банк, Сангийн яам, Монголбанк аж ахуйн нэгжүүдтэйгээ хэлэлцүүлгийн ширээний ард суугаад асуудлаа яриад үр дүн гаргах боломжтой эсэх талаар лавшруулан асуув.

“Хөтөлийн цемент шохойн үйлдвэр”-ийн газрын дарга байсан М.Бөх-Очир гэх хүний хүүхэд 2019 оноос хойш өв залгамжлах эрхийн талаар хөөцөлдөхөд өгөөгүй байхад Засгийн газраас эзэн холбогдогч байхгүй, өвлөж авах хүн байхгүй учраас төр авч байна гэх асуудлаар Сангийн сайдаас хариулт өгөхийг хүсээд, С.Бямбацогт гишүүний хувьд өөрөө хөөцөлдөж зээл авсан эсэх талаар асуултуудыг асуув.

Улсын Их Хурлын гишүүн Б.Баттөмөр нийт дүнгээрээ 862.3 тэрбум төгрөгийн 8 компанийн төслийг амжилттай хэрэгжсэн төслүүд гэж үзэж байгаагаар хэлсэн бол “Вестерн Холд” ХХК-ийн Төслийн удирдагч С.Жавхланбаатар С.Бямбацогт гишүүн, “Ховдын цементийн үйлдвэр”-тэй холбоотой асуултад бүрэн шаардлагаа хангасан зээлийн шийдвэр 2018 онд гарч, 2019 оны 09 дүгээр сарын 24-нд зээлээ авсан бөгөөд Хөгжлийн банкны хуульд заасан 10.1-ийн шалгуурыг бүрэн хангасан болох нь Хөгжлийн банкны цахим сайтад байршсан байгаа тухай хариулт өгсөн болно.

4.Сэтгүүлч Б.Отгон: - Сонсголд сэтгүүлчээс гадна Авлигатай тэмцэх газрын Олон нийтийн зөвлөлийг төлөөлж байгаа гэдгээ онцлоод хууль хяналтын байгууллагууд ямар үүрэгтэй байгаа талаар, тангараг өргөсөн гол үүрэг, зорилго нь юу вэ, гэмт хэрэг гарсан байхад таслан зогсоох, шалгах ёстой биз дээ гэх асуултуудыг асуув. Хуулиараа гэмт хэрэг гарсан байхад төрийн, нийтийн эрх ашгийн өмнөөс нэхэмжлэл гаргах эрхтэй ганц байгууллага болох прокурорын байгууллага сэтгүүлчдийг шалга гээд явж байхаас илүү прокурор өөрөө нийтийн эрх ашгийн өмнөөс нэхэмжлэл гаргах ажлаа хийхгүй юм уу гэдгийг Монгол Улсын Ерөнхий прокурор Б.Жаргалсайханаас асуув.

Түүнчлэн Сангийн сайд Б.Жавхлангаас түүний эхнэр Чингис хаан банкны хувьцаа эзэмшигчидтэй нэгдмэл ашиг сонирхолтой буюу хамтарсан компани эзэмшдэгийн хувьд түүнийг Чингис хаан банкны хамаарал бүхий этгээд мөн эсэхийг, Хөгжлийн банк өнөөдөр Чингис хаан банк руу асар их хэмжээний мөнгийг зээл хэлбэрээр гаргасан байхад Сангийн сайдын хувиар Хөгжлийн банкнийг хариуцаж болох уу гэдгийг, мөн арилжааны банкнаас авсан зээлээ Төрийн банк руу шилжүүлсэн асуудалдаа тайлбар өгөх зэрэг асуудлуудыг хөндөж асуув. Мөн зээл авсан Хассуурийн Ганхуяг гишүүн үгээ хэлэх болоогүй юу гэдгийг тодотгон асуусан.

Сангийн сайд Б.Жавхлан сэтгүүлч Б.Отгоны асуултад өөрийн хамааралтай хуулийн этгээдүүдээр дамжуулж Хөгжлийн банканд нэг төгрөгийн эрсдэл л учруулсан бол ямар ч хариуцлага хүлээхэд бэлэн байна гэдгээ илэрхийлээд Засгийн газраас Хөгжлийн банканд авч хэрэгжүүлж байгаа чанаргүй, муу зээлийг төлүүлэх ажилд хэн ч, юу ч саад болж чадахгүй, цаашид ч илүү их эрч хүчтэй ажиллаж Хөгжлийн банкнаас үүдэн гарах эрсдлүүдийг татвар төлөгчдийн нуруун дээр буулгахгүй, нэмж эрсдэл гаргахгүй байх тал дээр боломжит бүх арга хэмжээг авч ажиллана гэж хариулсан.

Улсын Ерөнхий Прокурор Б.Жаргалсайхан Хөгжлийн банкнаас 9 нэхэмжлэл бичих санал хүсэлт ирүүлснээс 2 хүсэлтийг нэмэлт материал бүрдүүлэхээр буцааж, 5 нэхэмжлэл бичсэн, 2 хүсэлтийг эрүүгийн гэмт хэргийн шинжтэй тул мөрдөх байгууллагад шилжүүлсэн гэв.

ДӨРӨВ.СОНСГОЛД ОРОЛЦОГЧДООС ИЛЭРХИЙЛСЭН САНАЛ, ДҮГНЭЛТ

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 120 дугаар зүйлийн 120.1.4-т заасны дагуу “сонсголд оролцогчид санал, дүгнэлтээ 5 минутад багтаан хэлнэ.” гэж заасны дагуу сонсголд оролцогчдоос өмгөөлөгч Н.Ариунболд, “Монцемент Билдинг Материалс” ХХК-ийн Технологи хариуцсан захирал Jungsoo Lee, СХД-ийн иргэн Д.Энхсайхан, гавьяат эдийн засагч, доктор, профессор Г.Янсанжав, “Бэрэн групп” ХХК-ийн Хөрөнгө оруулалт, хөгжлийн газрын захирал С.Батзориг, “Эрэл групп” ХХК-ийн үүсгэн байгуулагч Б.Эрдэнэбат, “Ард түмний штаб”-ын тэргүүн Б.Жагар, БГД-ийн иргэн О.Отгонбаатар, Монгол Улсын Их сургуулийн Эдийн засгийн сургуулийн багш Б.Отгонтөгс, Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн гишүүн Л.Отгонтуяа, БГД-ийн иргэн П.Өлзийнаран, Монголын Хуульчдын холбооны гишүүн, хуульч Г.Ганхөлөг, ХҮН-ын төлөөлөл Д.Гантулга нарын 13 иргэн санал, дүгнэлтээ илэрхийлсэн.

1.Б.Ариунболд өмгөөлөгч: - Маргааш өглөө давж заалдах шатны шүүх хуралдаан нь зарлагдсан Н.Мөнхбат захирлын асуудлаар тодорхой мэдээлэл өгөхөөр зорьж ирсэн гэдгээ онцлоод, 5-6 жилийн өмнөөс прокуророос Н.Мөнхбатыг 3 хэрэгт ялласнаас 2 нь цагаадсан, 1 нь хөөн хэлэлцэх хугацаа дууссан гэв.

“Мон лаа” ХХК-д хууль бусаар зээл олгосон гэдэг үндэслэлээр буруутгасан ч тогтоогдоогүй, 2017 онд хэрэг бүртгэлийн хэрэг үүсгээд хаасан нь сошиал, олон нийтийн сүлжээ, хэвлэл мэдээллийн хэрэгслээр маргаан дуулиан дэгдсэнтэй холбоотойгоор дахин нээгдсэн гэж тайлбарлаад олон нийтийн санаа бодолд автаж хэрэг бүртгэл, мөрдөн байцаах ажлыг явуулахгүй байхыг хуульчийн зүгээс хэлж, илэрхийлсэн. Яллагдагчаар татсан тогтоолын хувьд “Эрдэнэс монгол” компанийн зээл олгох асуудлыг шийдвэрлэсэн, зээл нь өнөөдрийг хүртэл төлөгдөөгүй байгаад буруутган шалгаж, цагдан хорьсон байгаа гэв.

Иймд шалгагдаж байгаа захирал байсан хүмүүсийг бүгдийг дуудаж ирүүлээд тодорхой тайлбарыг өгүүлэх нь зүйтэй гэв. Түүнчлэн Хөгжлийн банкиг үнэтэй байр авсан гэх асуудлын хувьд банк байр авахдаа нилээдгүй олон байгууллагуудаас үнийн санал аваад банкны шаардлага хангасан барилгыг 8.4 сая төгрөгөөр худалдаж авсан нь хууль зөрчин, давуу байдал олгож идсэн уусан зүйл байхгүй гэж зарласан.

Тэрээр нийт дүнгээрээ 2.5 тэрбум ам.долларын санхүүжилтийг гадаадын зах зээлээс босгосон банкирын хувьд 1.2 сая ам.доллаар сурталчилгаа хийсэн нь зээл олголтыг сурталчлах бус Монгол Улсыг гадаадын зах зээл дээр том хөрөнгө оруулагчдын өмнө гадаадын том хэвлэл, мэдээллийн байгууллагуудаар дамжуулан сурталчлахад тодорхой хэмжээний мөнгө шаардлагатай байдгийн хүрээнд том бондуудыг босгохын тулд тодорхой хэмжээний зардал гаргаж Монгол Улсыг сурталчилсан гэж тайлбарласан болно.

2.Jungsoo Lee: - “Монцемент Билдинг Материалс” ХХК-ийн Технологи хариуцсан захирлаар ажилладаг, Олон улсын цементийн салбарт 45 жил, Солонгос, Филиппин, Хятадад 13 жил ажилласан туршлагатай гэдгээ илэрхийлээд Цементийн үйлдвэр аливаа улс орны хамгийн чухал салбарын хувьд Солонгос улс 1957 оноос эхлээд цементийн үйлдвэр барьж эхэлснээс сүүлийн жилүүдэд нийт 20 төслүүдэд нь ажилласан гэдгээ онцолсон.

Цар тахлын үед бусад улсын Засгийн газрууд цементийн үйлдвэрийг маш эрчимтэй дэмжиж, цалинг нь төрөөс олгох дэмжлэг нэг жилийн хугацаанд хэрэгжүүлсэн талаар мөн дурдав.

3.Сүхбаатар дүүргийн иргэн Д.Энхсайхан: - Эрүүгийн хуульд авлига, албан тушаалын хэрэгт холбогдсон албан тушаалтныг нийтийн албанд насаар нь сонгохгүй байх, хөрөнгийг нь хураадаг, хорих ялаар ялладаг байх зарчмуудыг тусгах талаар санал хэлээд Улсын Их Хурлын гишүүд хууль санаачлах эрхтэйн хувьд Өр барагдуулах хуулийг яагаад ярихгүй байгаа талаар хөндөөд цаашид Түр хороо байгуулаад яаралтай хэлэлцэх байх гэж бодож байгаагаа илэрхийлсэн.

4. Гавьяат эдийн засагч, доктор, профессор Г.Янсанжав: - Улсын Их Хурлын ажлын хэсэг сайн ажиллаж, сайн дүгнэлт гаргасан гэдгийг онцлоод банкны урт хугацаатай зээлийн асуудлаар европт сурсан мэргэжлийн хүний хувьд шаардлагатай бол дуудаж хамтран ажиллахыг Сангийн сайд Б.Жавхланд хандаж хэлээд, өрийг барагдуулах, үйлдвэрүүдийг цааш нь ажиллуулах, ажлыг нь

боловсронгуй болгох талаар Улсын Их Хурал, Засгийн газар зөв чиглэл өгөх хэрэгтэй гэдгийг хэлсэн. Мөн Хөгжлийн банкнийг хэрхэвч дампууруулж болохгүй талаар онцгойлон дурдав.

5.Баянгол дүүргийн иргэн О.Отгонбаатар: - Н.Алтанхуяг гишүүнийг Авлигатай тэмцэх газарт шалгуулах саналтай байна, Авлигатай тэмцэх газар шалгах уу, шалгах үндэслэлтэй байвал Улсын прокурор нэрийг нь татах уу гэдгийг асуув. Улсын Их Хурал нэг удаагийн хууль батлаад Хөгжлийн банканд үүсээд байгаа нөхцөл байдлыг шийдэж болохгүй юу гэсэн санал илэрхийлсэн.

6.“Бэрэн групп” ХХК-ийн Хөрөнгө оруулалт, хөгжлийн газрын захирал С.Батзориг: - “Барилгын арматурын үйлдвэр”-т 27.2 сая ам.доллар, “Хангай хотхоны 5 дугаар блок”-ийн төсөлд 11.7 сая ам.долларын зээлийг хоёр төсөлд зориулж авсан бөгөөд стратегийн ач холбогдолтой бүтээгдэхүүн учраас гаднын хөрөнгө оруулалт авахыг хүсээгүй, үйлдлээрээ хийж харуулна гэсэн ойлголттойгоор олон нийтэд үйл ажиллагаагаа сурталчлаагүй алдаа гаргасан учраас цаашид олон нийтэд нээлттэй үйл ажиллагаагаа танилцуулж байхаа илэрхийлсэн.

7.”Эрэл групп” ХХК-ийг үүсгэн байгуулагч Б.Эрдэнэбат: - 220 мянган өрхийн гэр хорооллыг агаар, хөрс, усны бохирдлоос салгах төсөл нь Улсын Их Хурлын 23, 36 дугаар тогтоол, Засгийн газрын 171, 180 дугаар тогтоолд үндэслэсэн стратегийн ач холбогдол бүхий төсөл бөгөөд Эрэл компани 2017 онд үйлдвэрийг ашиглалтад оруулснаас хойш бүтэн 4 жил ажилгүй зогсож байгаа хариуцлагад Засгийн газрыг шүүхэд өгөлгүй тэвчээртэй байгаа гэж тодотгосон.

8.Ард түмний штабын тэргүүн Б.Жагар: - Монголбанкныханд Иргэний хуулийн 218.1-т *“төлбөр гүйцэтгэх хугацаа болохоос өмнө мөнгөний ханш өссөн, буурсан бол үүрэг үүсгэх үеийн ханшаар тооцож төлбөрийг төлнө”* гэх заалтыг хэрэгжүүлж баялаг бүтээгчдээ хамгаалах талаар зөвлөгөө өгч, Улсын Их Хурлын гишүүдэд хандан Иргэний хуулийн 222.2-т *“үүрэг гүйцэтгэгчийн гэм буруутайгаас болоогүй бол үүрэг гүйцэтгэгчийг хугацаа хэтрүүлсэн гэж үзэхгүй”* гэдэг хуулийн зүйл заалтыг дурдаад шударга ёсыг өөрсдөөсөө эхлэхийг шаардаж, нийт шударгаар баялаг бүтээж байгаа аж ахуйн нэгжүүд, иргэдийн зээлийг жилийн 3 хувьд шилжүүлэх шаардлагыг удаа дараа хүргүүлж байгаагаа илэрхийлэв. Оюутолгойн ажлын хэсгийг 200 гаруй хүний өргөн бүрэлдэхүүнтэй ажиллан үр дүн гарсан шиг Иргэний хөдөлгөөнийхөн, сэтгүүлч нарыг оролцуулан Улсын Их Хурлын ажлын хэсгийг өргөтгөн, өргөтгөсөн бүрэлдэхүүнтэй ажиллуулах санал гаргасан талаар үг хэлсэн.

9.Монгол Улсын Их сургуулийн Эдийн засгийн сургуулийн багш Б.Отгонтөгс: - Хөгжлийн банк нь Олон улсын хөрөнгийн зах зээлүүдээс ихээхэн хэмжээний бондуудыг Засгийн газрын баталгаатай, сүүлийн жилд баталгаагүйгээр авч чадсан бөгөөд Олон улсын мэргэжлийн байгууллагуудтай хамтран ажиллаж, дэлхийн санхүүгийн зах зээл дээр бонд босгож, гэрээ хэлэлцээр хийж сурч байгаа, дэлхийн санхүүгийн интеграцчилалд орсон, Олон улсын санхүүгийн маш сайн түүх гаргаж ирсэн банк гэж үзэж байгаагаа илэрхийлсэн.

Тэрээр ХҮН-ыг төлөөлж байгаагаа онцолсон ба тус намын дэргэдэх судалгааны хүрээлэн, тинктанкийн эдийн засагчид Хөгжлийн банкны асуудал гарснаас хойш тодорхой хэмжээний судалгаа хийж, цаашид хэрхэх талаар дараах зөвлөмжүүдийг гаргасан байна. Үүнд:

- нэгдүгээрт, зээлүүдийг эргэн төлүүлэх талаар банк маш сайн ажиллах,
- хоёрдугаарт, төлж чадахгүй байгаа төсвөөс эргэн төлөгдөх нөхцөлтэй төслүүдийн зээлийг үнэт цаасны хэлбэрээр дахин арилжаалах, муу зээлүүдийг худалдаж авах санхүүгийн хоёрдогч зах зээлүүдийг бүрдүүлэх,
- Монголбанк, Сангийн яамны удаа дараагийн зөвлөмжийг биелүүлэх мэргэжлийн багуудыг ажиллуулах /Олон улсын, мэргэжлийн, ёс зүйтэй санхүүчид энэ банкныг хэцүү байдлаас гаргаж чадна/,
- 5-6 жилийн хугацаанд энэ банкны төрийн 100 хувийн эзэмшлээ багасган 80 хувь болгож, 20 хувийг арилжааны банкуудыг оруулж, үйл ажиллагааг явуулах зөв механизмтай банк болгох,
- мэргэжлийн эдийн засагчид, санхүүчдийн дутагдалтай байдлаас үүдсэн ханшийн зөрүү зэрэг асуудлыг банкны хажууд судалгааны нэгж байгуулан хянадаг тогтолцоог бий болгох хэрэгтэй гэв.

10.Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн гишүүн Л.Отгонтуяа: - Тогтвортой байдлын зөвлөлийн гол үүрэг бол төсвийн алдагдлыг зохистой хязгаарт барих буюу дотоодын нийт бүтээгдэхүүний 20 хувьд, зээлийг дотоодын нийт бүтээгдэхүүний 40 хувиас хэтрүүлэхгүй байлгах тал дээр санал, дүгнэлтээ өгөх байдаг гэдгээ дурдаад 3 их наяд төгрөгийг төсөв рүү шилжүүлсэн шиг дахиад 762.6 тэрбум төгрөгийг Төрийн өмчит аж ахуйн нэгжүүдийн төсвийн шинжтэй өр байдлаар төсөв рүү шилжүүлбэл төсвийн байдалд том дарамт болох тул Улсын Их Хурал ард иргэдээ төлөөлж, Төрийн өмчийг өмчлөгчийнхөө байр сууринаас хууль, дүрэм журамдаа ямар өөрчлөлт хийвэл ийм байдал дахиад гарахгүй байх вэ гэдэгт анхаарч ажиллахыг хүсэж буйгаа илэрхийлэв.

Улсын Их Хурал Хөгжлийн банкны үйл ажиллагаатай холбоотой худалдан авалтыг сайжруулах, хууль хяналтын байгууллага улсад учирсан хохирлыг барагдуулах арга хэмжээ авах дүгнэлт, зөвлөмжийг сонсож арга хэмжээ авах, хууль дүрэмдээ өөрчлөлт оруулахад анхаарах байтал сонсдоггүйгээс өнөөдрийн энэ нөхцөл байдал үүссэн байх боломжтой гэж дүгнээд зөрчилтэй асуудлыг засах ажлыг Улсын Их Хурал санаачлан Түр хороо эсхүл ажлын хэсэг хэлбэрээр ажиллан санал, зөвлөмжөө өгч, институтийнхээ чадавхыг бэхжүүлэн, хариуцлагыг дээшлүүлээд хариуцлагатай байх үүднээс Улсын Их Хурал өөрөө хяналт тавих байдлаар ажиллахыг хүсэж байгаа талаар санал гаргасан.

11.Баянгол дүүргийн иргэн П.Өлзийнаран: - Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн зөвлөмжийг хэрэгжүүлэхээр 2012 оны 12 дугаар сарын 15-нд байгуулагдсан Бодлогын зөвлөлийн дарга, тухайн үеийн эрх баригч намын дарга Н.Алтанхуяг хамгийн гол буруутан бөгөөд Хөгжлийн банкны зээл гаргалтыг Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн зөвлөмжийн биелэлтийг хангах нэрээр Бодлогын зөвлөл нь шийдэж байсан тухай хэлээд, хариуцлага тооцох хуулийн заалтыг чангатгах шаардлагатай бөгөөд хариуцлага сул учир хүмүүс бүгд хулгай хийдэг тиймээс одоогийн Улсын Их Хурлын гишүүдэд бүх эрх мэдэл байгаа тул хуулийг чангатгах, хөөн хэлэлцэх хугацааг байхгүй болгох талаар саналаа илэрхийлсэн.

12.Хуульч, өмгөөлөгч Э.Ганхөлөг: - Хөгжлийн банктай холбоотой яригдаж байгаа асуудлууд Монгол Улсад хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа хуулийн дагуу бүгд шийдэгдэнэ гэдэгт эргэлзэхгүй байгаагаа илэрхийлээд хууль, шүүхийн байгууллага улс төрийн нөлөөнөөс ангид байж чадвал голтой шийдвэр гаргадаг гэв. Зээлийн ард маш олон хүмүүсийн ажил амьдрал, маш олон аж ахуйн нэгжүүдийн

бизнес яригдаж байгаа нь цаашлаад манай эдийн засагт маш чухал нөлөө үзүүлэх тул маш их анхаарал хандуулж ажиллахыг, зээлээ төлж чадахгүй нөхцөл байдал үүссэн, үүнийгээ барьцаа хөрөнгөөрөө хангуулъя гэсэн нэлээд олон аж ахуй нэгжүүдийн барьцаа хөрөнгийг хангуулах асуудлыг түргэн, шуурхай шийдвэрлэж өгөхийг уриалсан. Түүнчлэн бизнесийн салбар маш эмзэг бөгөөд хариуцлагагүй мэдэгдлээс болоод бизнес нь эрсдэлд орох, зогсох, гацах мөн худалдан авалт, борлуулалт нь зогсох эрсдэлтэй байдлууд үүсээд байгаа учраас Авлигатай тэмцэх газрын удирдлагад хариуцлагагүй мэдэгдэл хийхгүй байхад анхаарч ажиллах талаар санал хэлсэн.

13.Нийслэлийн ИТХ-ын төлөөлөгч /Хөдөлмөрийн Үндэсний Нам/-ын төлөөлөл Д.Гантулга: - Манай ХҮН-ын гишүүн, Улсын Их Хурлын гишүүн Т.Доржхандын ярьсан эдийн засгийн хариуцлагын хувьд зээл авсан хүмүүсээр нь төлүүлэх, хуулийн хариуцлагын хувьд нэр холбогдоод байгаа гишүүд халдашгүй байдлаа зогсоож байгаад шалгуулах, улс төрийн хариуцлагын хувьд хулгайчуудыг төрөөс хол байлгах талаар саналуудыг хэлсэн.

Улсын Их Хурлын гишүүн, сонсгол даргалагч Ж.Бат-Эрдэнийн саналаар 2 аж ахуйн нэгжийн төлөөллийн саналыг сонссон.

“Ганхүдэр орд” ХХК-ийн гүйцэтгэх захирал Р.Эрдэнэбаяр: - 2012 онд тухайн үйлдвэр төмрийн хүдрийг нойтон аргаар баяжуулах чиглэлээр үүсгэн байгуулагдаад 5 жил үйл ажиллагаагаа амжилттай явуулж, компанийн орлого, бизнесийн ашгаараа төмрийн хүдрийн дараагийн шатны үйлдвэр болох баяжуулах үйлдвэрийг барьж эхэлсэн бөгөөд суурийн ажлыг хийх явцдаа 2017 онд Хөгжлийн банканд хүсэлт тавьж, хангалттай барьцаа хөрөнгө үнэлэгдсэнээс 50 хүрэхгүй хувьд төслийн зээлийг олгосон гэв.

Төслийг амжилттай хэрэгжүүлж, 2017 онд үйлдвэрээ бариад 2019 онд үйлдвэрийг бүрэн хүчин чадлаар нь ашиглалтад оруулсан ба анх 60 хүний ажлын байрыг бий болгох зорилготой байсныг 4 дахин нэмэгдүүлж, үйлдвэрийн хүчин чадлыг 3 дахин нэмэгдүүлж, амжилттайгаар үйл ажиллагаа явуулж байсан хэдий ч сүүлийн хоёр жил Ковид-19 цар тахлын нөлөөгөөр үйл ажиллагаа тодорхой хэмжээнд доголдоход хүрч, боловсон хүчний хомсдолд орох, чанар, технологийн алдаа дутагдал гарах, бүтээгдэхүүн доголдох, үнэгүйдэх зэрэг асуудлууд үүссэн хэдий ч үйл ажиллагаагаа амжилттай явуулсаар ирсэн гэж тайлбарласан.

Компанид 2 том хүндрэлтэй асуудал байдгаас: нэгдүгээрт, бүтээгдэхүүнээ 100 хувь түүхийгээр нь Хятад улс руу гаргадаг манай компанийн хувьд төмөр зам тээвэр, ложистикийн асуудал хүндээр нөлөөлж, түүхий эдээ татах нөхцөл боломж байхгүйгээс үйлдвэр доголдох, тасалдах нөхцөл байдал байнга үүсдэг бол хоёрдугаарт, бүтээгдэхүүний 5 хувийг боловсруулж, 95 хувиа түүхийгээр нь гаргадаг ашиглалтын лицензгүй, боловсруулах үйлдвэр эрхэлдэг манай компанид АМНАТ маш өндөр дарамт болдог бөгөөд 2019 оны 04 дүгээр сард бий болсон АМНАТ байгаагүй бол (өнөөдрийн байдлаар 3.4 тэрбум төгрөгийн АМНАТ-ын өр төлбөртэй байгаа) зээлээ төлөх боломжтой байсан гэж тайлбарласан.

Мөн 2021 оны 11 дүгээр сараас хойш үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнээ экспортод гаргаж чадаагүй, гаалийн хяналтын талбай дээр манай үйлдвэрийн нойтон баяжмал 8,000 тонн, хорголжин баяжмал 10,000 тонн байгааг Хөгжлийн банкныхан мэдэж байгаагийн хувьд тэдгээр бараа бүтээгдэхүүнийг экспортлон өр төлбөрөө

барагдуулахаа илэрхийлж, тээвэр ложистик, АМНАТ, боловсон хүчин, Ковидын асуудал байна гэдгийг удаа дараа мэдэгдсэн гэжээ.

“Кью Эс Си” ХХК-ийн гүйцэтгэх захирал Э.Шижир: - “Кью Эс Си” ХХК нь 2010 оноос хойш уул уурхайн металлургийн цогцолбор 20 гаруй төсөл, хөтөлбөрүүдийг Төр, хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд хэрэгжүүлж ирсэн “Дарханы төмөрлөгийн үйлдвэр”-ийг концессын гэрээгээр эзэмшиж байгаа компани гэдгийг тайлбарлаад 2014 оны 03 дугаар сард эхэлсэн төсөлд Хөгжлийн банкнаас 2014 оны 11 дүгээр сард 130 тэрбум төгрөгийн зээл авснаас 89 тэрбум төгрөгийг төлж, зээлийн үлдэгдэл 192 тэрбум төгрөг байгаа талаар тайлбарласан.

2018 оныг хүртэл зээлийн хэвийн төлөлттэй явж байсан ба Засгийн газрын 2018 оны 7 дугаар тогтоолоор уг зээлийг Засгийн газар өөртөө шилжүүлэн авахад Хөгжлийн банканд зээлийг үргэлжлүүлэн төлөх хүсэлт гарган шүүхэд хандаж, ялагдсанаар зээлийг Засгийн газарт төлөх шийдвэр хэвээр үлдсэн гэв. 2022 оны 01 дүгээр сард Хөгжлийн банканд зээлээ төлөх ёстой гэдэг шийдвэр гарсан ба зээлийн асуудлыг яаж шийдвэрлэх талаар Хөгжлийн банкт хуваарь гаргаад үргэлжлүүлэн төлөхөд эсвэл Засгийн газарт шилжүүлсэн хувилбараар ч шийдэхэд бэлэн байгаа саналаа илэрхийлсэн гэдгээ тайлбарласан.

ТАВ.УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮДИЙН ХЭЛСЭН ҮГ

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 120 дугаар зүйлийн 120.1.6-д *“гишүүн оролцогчоос асуулт асууж, хариулт авч дууссаны дараа 5 минутад багтаан үг хэлж болно”* гэж заасны дагуу Улсын Их Хурлын гишүүн Х.Ганхуяг, Т.Доржханд, Б.Баттөмөр, Б.Энхбаяр, Х.Булгантуяа, М.Оюунчимэг, Б.Бат-Эрдэнэ нарын нийт 7 гишүүн үг хэлэв.

1.Улсын Их Хурлын гишүүн Х.Ганхуяг: - Сүүлийн 2 жил гүтгүүлж байгаа талаараа болон сэтгүүлчид эргэлзэх, асуух эрхтэй гэдгийг хэлээд экспортын зориулалттай зээл авсан өөрийн эгчийн компанийн талаар мэдээлэл өгч, Б.Баттөмөр гишүүний дурдсан улс төрийн нөлөө, хамаарал бүхий 20 хүний нэрсээс Улсын Их Хурлын гишүүн Г.Амартүвшин, Г.Дамдинням нарыг хасаж, “Бэрэн групп” ХХК-д хувь эзэмшдэгийнх нь хувьд Б.Баттөмөр гишүүнийг нэмж, шалгуулах нь зүйтэй гэв.

2.Улсын Их Хурлын гишүүн Т.Доржханд: - Сонсголын дүнд хуулийн, улс төрийн, ёс зүйн, санхүүгийн дөрвөн хариуцлагыг хэлэлцэж, цаашид хариуцлага тооцож, үр дүн гаргах нь чухал гэж дүгнэсэн. Үүнд:

- хуулийн хариуцлагын хүрээнд асуусан асуултуудын хариултауд хангалттай байгаагүй ч цаашид иргэд, хэвлэлийн байгууллага бүгд хамтран шахаж ажиллан хариуцлагыг тооцуулан, үр дүн гаргах талаар,
- улс төрийн хариуцлагын хүрээнд Монгол Ардын Намын Ерөнхий нарийн бичгийн дарга хариуцлага тооцохоо тодорхой илэрхийлсэн тул сэтгүүлч нар, сонсголд оролцогчид бүгд хариуцлага нэхэж, улс төрийн хариуцлага тооцуулах, намаасаа тодорхой хугацаанд түдгэлзэж, хуулийн байгууллагаараа шалгуулах нь зүйтэй талаар,
- ёс зүйн хариуцлагын хувьд Б.Бат-Эрдэнэ гишүүн хариуцлага тооцно гэдгээ илэрхийлсэн,

- санхүүгийн хариуцлагын хувьд эрдэм шинжилгээний хүрээлэнгээс тодорхой зөвлөмжийг албан бичгээр өгч, түүний дагуу ажиллах хэрэгтэй талаар тус тус дүгнэн хэлсэн. Мөн тэрээр сонсголоор асуудал шийдэгдэхгүй ч Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хууль батлагдсаны дагуу хянан шалгах Түр хороо байгуулахаар нийт 17 гишүүн гарын үсэг зурсан бөгөөд 19 гишүүний тоогоор Улсын Их Хуралд өргөн мэдүүлнэ гэж тодотголоо.

3.Улсын Их Хурлын гишүүн, Ажлын хэсгийн ахлагч Б.Баттөмөр: - Ажлын хэсэг 45 орчим хоног ажиллаад 7000 гаруй хуудас материалд тулгуурлан 150 хуудас ажлын тайлан гаргасныг 20 минутад багтааж ярихад хүндрэлтэй байсан талаар дурдаад, хуучин шалгалтуудтай харьцуулахад 66 төслийг газар дээр нь очиж шалган, мэргэжлийн үнэлгээчдээр үнэлүүлэх ажил хийсэн гэдгээ онцолж, хянан шалгах Түр хороо байгуулагдахад хийгдэх ихэнх ажлыг ажлын хэсэг хийсэн гэж дүгнэсэн. Мөн Шүүхийн бус журмаар өр барагдуулах хуулийн төслийг өргөн мэдүүлсэн байгааг ард нийтээр нээлттэй хэлэлцэнэ гэсэн мэдээлэл өгөв.

Х.Ганхуяг гишүүний хэлсэн “Бэрэн групп” ХХК-ийн 5 хувийг эзэмшдэггүйгээ хариуцлагатайгаар мэдэгдэж, эзэмшдэг бол хариуцлага хүлээхэд бэлэн гэдгээ илэрхийлсэн. Түүнчлэн Хөгжлийн банкны асуудлыг шалгаж байх явцад Хөгжлийн банкны үе үеийн удирдлагууд эрх мэдлийг дагасан олон сорилтуудыг давж чадаагүй, анхнаасаа юу хийх ойлголтгүйгээр зээл гаргасан гэж дүгнэлээ.

4.Улсын Их Хурлын гишүүн Б.Энхбаяр: - Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн дагуу Улсын Их Хурал анхны Ерөнхий хяналтын сонсголыг хийлээ гээд Улсын Их Хурал дээр Түр хороо байгуулж ажиллахыг дэмжиж гарын үсэг зурсан гэж мэдээлэв. Түр хороо сонсголоор хэлэлцэгдсэн болон хэлэлцэгдээгүй, удахгүй илрэх, ачигдах олон хүний асуудал, олон авлига, хулгайн асуудлыг хуулийн байгууллагатай хамтарч дэмжлэг үзүүлж эцэслэн шийднэ гэж үзэж байгаагаа хэлээд Улсын Их Хурлын гишүүдэд хандан хариуцлагатай үе ирж байгааг сануулсан.

5.Улсын Их Хурлын гишүүн Х.Булгантуяа: - 1.8 их наяд гэдэг бол маш их мөнгө, ийм их хэмжээний мөнгийг үргүйдүүлэх ажлыг эхлүүлсэн хүнтэй холбоотой үнэн зөвийг хууль хяналтын байгууллага тогтоож, шүүх шийдвэрээ гаргах ёстой, мөн Түр хороо байгуулагдах нь зүйтэй гэж үзэж буйгаа илэрхийлсэн.

6.Улсын Их Хурлын гишүүн М.Оюунчимэг: - Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн хүрээнд анхны нээлттэй сонсголыг Хөгжлийн банкны асуудлаар хийж, хэвлэл, мэдээллийнхэн гол үүрэгтэй оролцсонд талархаж байгаагаа илэрхийлсэн. Нэг харамсалтай зүйл нь гарын үсэг зурсан, гардаж гүйцэтгэсэн залуучууд хохироод, жинхэнэ цаана байгаа том эздийн тухай яриа гарахгүй үлддэг байдлыг Хөгжлийн банкаар дуусгавар болгох асуудлыг Улсын Их Хурлын танхимаас хамтдаа шийдвэрлэе гэсэн санал хэлээд бие биеэсээ айхгүй байж, шударга хандаж, хууль хүчний байгууллагатайгаа нэгдэн ажиллаж үр дүнд хүрснээр ард түмэнд зөв ойлголт өгөх хэрэгтэй гэж дүгнэсэн.

7.Улсын Их Хурлын гишүүн Б.Бат-Эрдэнэ: - Улсын Их Хурлаас байгуулагдсан ажлын хэсэг өргөтгөсөн өргөн бүрэлдэхүүнтэй ажиллаж, зээлдэгч тус бүрийн материалтай танилцан, баримт бичигт тулгуурлан, хуулийн эрх хэмжээний хүрээндээ зээл, хэрэгжиж байгаа төсөл бүрээр бодитой газар дээр нь танилцаж, үнэлгээ хийлгэн, зээл авахдаа шалгуур нөхцөлүүдийг хангасан эсэхийг тодорхой шалгаж сайн ажилласан гэв.

Хөгжлийн банкны зээлдэгчийн харилцан хамаарлын схем танилцуулгыг хуулийн байгууллагын хэмжээнд хийж чадахгүй ч өөрсдийн хэмжээнд Хөгжлийн банк, Улсын бүртгэлийн газар, бусад холбогдох байгууллагуудаас гаргуулсан материал дээр тулгуурлан нийт 22 аж ахуйн нэгжийн харилцан хамаарлыг гарган танилцуулсанд Улсын Их Хурлын гишүүд эмзэглэж хүлээж авахгүйгээр, хууль хяналтын байгууллагаар шуурхай шалгуулаад нэг талдаа гарах ёстой гэв.

Түүнчлэн хяналт шалгалтын хууль батлагдсантай холбоотой Түр хороо байгуулж, Түр хороо чанаргүй, муу зээлийн ангилалд орсон 1.8 их наяд төгрөгийг төлүүлж барагдуулах зорилтын төлөө ажиллах ёстой гэж бодож буйгаа илэрхийлсэн.

Сонсгол даргалагч, Улсын Их Хурлын гишүүн Ж.Бат-Эрдэнэ: - Монгол Улсын Хөгжлийн банкнаас санхүүжүүлсэн төсөл, хөтөлбөрийн хэрэгжилтэд хяналт тавьж, шалгалт хийсэн талаар холбогдох эрх бүхий байгууллагуудын тайлан, мэдээлэлтэй танилцах Ерөнхий хяналтын сонсгол 09.00 цагаас эхэлж 12 цаг үргэлжлээд өндөрлөж байгаатай холбогдуулан сонсголын хүрээнд танилцуулга хийсэн ажлын хэсгийн гишүүд Б.Баттөмөр, Б.Бат-Эрдэнэ, С.Чинзориг, Ц.Даваасүрэн, Б.Пүрэвдорж нарт том хэмжээний дүгнэлтийг гаргаж ирсэнд талархлаа илэрхийллээ.

Монгол Улсын Их Хурал Хөгжлийн банкны асуудлыг анхааралдаа авч, Улсын Их Хурлын даргаас хяналт шалгалтын ажлын хэсгийг байгуулан ажиллаж, хуулийн дагуу хяналтын сонсголыг санаачилж, Байнгын хороон дээр сонсголын талаарх шийдвэрийг гаргаж Монгол Улсын Их Хурлын Хяналт шалгалтын тухай хуулийн дагуу анхны сонсголыг хийж байгааг том алхам гэж дүгнэв.

Тэрээр зээлтэй холбоотой хариуцлага алдсан асуудлууд нэлээдгүй байгааг хэлээд Хөгжлийн банк Солонгос захиралтай багтай байсан үед бүтээн байгуулалт хийхийн тулд барилга, хот байгуулалттай холбоотой компаниудыг дэмжүүлэх, 100 мянган айлын орон сууцад зайлшгүй хөрөнгө оруулалт оруулах, мөн Улаанбаатар хотыг бүх аймгийн төвтэй холбох авто замын сүлжээ байгуулах хүрээнд аж ахуйн нэгжүүдэд концессын хэлбэрээр дэмжлэг үзүүлэх зэрэг саналуудыг тавьж байсан ч буцаж эргэлтэд ордоггүй буюу орлого олохгүй төсөл, хөтөлбөр байна гэж үзээд санхүүжүүлэх боломжгүй гэх хариулт өгч байсан зарчмынхаа дагуу явж байсан банк байсан тухай тодотголоо.

Сонсгол даргалагч ард иргэдийн мэдэх эрхийг эдлүүлж, төрийн үйл ажиллагааг нээлттэй явуулсанд цаг заваа гаргаж оролцсон Төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж, иргэдэд баярласнаа илэрхийлснээр сонсголын үйл ажиллагаа 21 цаг 12 минутад өндөрлөв.

ЗУРГАА.ЕРӨНХИЙ ХЯНАЛТЫН СОНСГОЛЫН НЭГДСЭН САНАЛ, ДҮГНЭЛТ

Улсын Их Хурлын Эдийн засгийн байнгын хорооны 2022 оны 03 дугаар сарын 11-ний өдрийн 01 дүгээр тогтоолоор “Монгол Улсын Хөгжлийн банкнаас санхүүжүүлсэн төсөл, хөтөлбөрийн хэрэгжилтэд хяналт тавьж, шалгалт хийсэн талаарх холбогдох эрх бүхий байгууллагуудын тайлан, мэдээлэлтэй танилцах Ерөнхий хяналтын сонсгол”-ыг зохион байгуулахаар шийдвэрлэсний дагуу 2022 оны

03 дугаар сарын 29-ний өдөр Монгол Улсын Хөгжлийн банкнаас санхүүжүүлсэн төсөл, хөтөлбөрийн хэрэгжилтэд хяналт тавьж, шалгалт хийсэн талаарх холбогдох эрх бүхий байгууллагуудын тайлан, мэдээлэлтэй танилцах Ерөнхий хяналтын сонсголыг зохион байгуулсан.

Ерөнхий хяналтын сонсголыг Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хууль, Нийтийн сонсголын тухай хууль, Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд заасны дагуу Улсын Их Хурлын Эдийн засгийн байнгын хороо, Улсын Их Хурлын Тамгын газар зохион байгуулж, сонсголд Улсын Их Хурлын гишүүд, сонсголд оролцогчдоос гарсан санал, дүгнэлтийг нэгтгэн дараах байдлаар танилцуулж байна.

Үүнд:

1. УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮД

- Хөгжлийн банкнаас санхүүжүүлсэн төсөл, хөтөлбөрийн хэрэгжилтийн явцыг шалгахад чанаргүй ангилалд орсон 61 төсөлтэй холбоотой 1.8 их наяд төгрөгийн хохирлыг хэрхэн барагдуулах талаар Монгол Улсын Засгийн газар, Хөгжлийн банк хамтран ажиллах, цаашид авах арга хэмжээний төлөвлөгөөг боловсруулан хэрэгжүүлэх;
- Хөгжлийн банкны зээлдэгч компаниудын харилцан хамаарал, Улсын Их Хурлын өмнө ажиллаж байсан болон одоо ажиллаж буй гишүүд, Хөгжлийн банкны өмнөх удирдлагуудтай хэрхэн хамаарч байгаа талаарх зураглалыг тодорхой болгож олон нийтэд ил тод болгох;
- Хөгжлийн банкнаас санхүүжүүлсэн төсөл, хөтөлбөрийн хэрэгжилтийг нарийвчлан хяналт шалгалт хийх, зээл эргэн төлөлт, учирсан хохирлыг нөхөн төлүүлэх зэрэг асуудлаар Улсын Их Хурлаас хянан шалгах Түр хороо байгуулан ажиллах;
- Монголбанк төгрөгийн тогтвортой байх асуудлыг шийдэх үүрэг хүлээдгийн хувьд ханшийн эрсдэлд орж байгаа компаниудын асуудлыг тодорхой хэмжээгээр шийдвэрлэх, Хөгжлийн банк, Сангийн яамтай хамтран ажиллах.

2. ХЭВЛЭЛ МЭДЭЭЛЛИЙН ТӨЛӨӨЛӨЛ

- Хөгжлийн банкны санхүүжилт, хэрэгжүүлсэн төсөл, хөтөлбөрт нэр холбогдсон Улсын Их Хурлын гишүүд болон Хөгжлийн банкны удирдлагуудтай холбоотой асуудлуудыг Улсын Их Хурлаас шалгаж, холбогдох хариуцлагыг хүлээлгэх чиглэлээр ажиллах;
- Ханшийн зөрүүнээс эрсдэл хүлээсэн аж ахуйн нэгжүүдтэй гурван талт хэлэлцээрт орох буюу Хөгжлийн банк, Сангийн яам, Монголбанк аж ахуйн нэгжүүдтэй хамтарсан хэлэлцүүлгийг зохион байгуулах.

3. СОНСГОЛД ОРОЛЦОГЧ

- Улсын Их Хурлаас Хөгжлийн банкны Улсын Их Хурлын гишүүд хууль санаачлах эрхтэйн хувьд Өр барагдуулах хуулийг батлуулах, цаашид Улсын Их Хурлын хянан шалгах Түр хороо байгуулж, яаралтай хэлэлцэх;

- Засгийн газар, Монголбанк, Хөгжлийн банкнаас санхүүжүүлсэн төсөл, хөтөлбөрийн зээлүүдийг эргэн төлүүлэх талаар тодорхой арга хэмжээ авч ажиллах;
- Зээлээ төлж чадахгүй байгаа, төсвөөс эргэн төлөгдөх нөхцөлтэй төслүүдийг зээлийн үнэт цаасны хэлбэрээр дахин арилжаалах, муу зээлүүдийг худалдаж авах, санхүүгийн хоёрдогч зах зээлийг бүрдүүлэх;
- Монголбанк, Сангийн яамны удаа дараагийн зөвлөмжийг биелүүлэх мэргэжлийн багуудыг ажиллуулах /Олон улсын, мэргэжлийн, ёс зүйтэй санхүүчид энэ банкиг хэцүү байдлаас гаргаж чадна/;
- 5-6 жилийн хугацаанд энэ банкны төрийн 100 хувийн эзэмшлээ багасган 80 хувь болгож, 20 хувьд арилжааны банкуудыг оруулж, үйл ажиллагааг явуулах зөв механизмтай банк болгох,
- мэргэжлийн эдийн засагчид, санхүүчдийн дутагдалтай байдлаас үүдсэн ханшийн зөрүү зэрэг асуудлыг банкны хажууд судалгааны нэгж байгуулан хянадаг тогтолцоог бий болгох.

--oOo--